

ТӨРИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

| | |
|---|----|
| Аудитын гэрчилгээ..... | 2 |
| 1. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил..... | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... | 4 |
| 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт..... | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин..... | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал..... | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар..... | 6 |
| 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн..... | 7 |
| 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл..... | 7 |
| 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... | 8 |
| 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..... | 8 |
| 2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 8 |
| 2.11. Шилэн дансны мэдээлэл..... | 8 |
| 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга..... | 8 |
| 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 8 |
| 2. Менежментийн захидал..... | 10 |
| 3. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 12 |
| 4.1 Санхүүгийн байдлын тайлан..... | 12 |
| 4.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 14 |
| 4.3 Мөнгөн гүйлгээний тайлан..... | 16 |
| 4.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 18 |
| 4.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 19 |
| 5. Хавсралт..... | 21 |
| 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... | 21 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.МАНДАХ
ТАНАА

2019.03.15 № 06/436
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

1. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мандах Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасанболно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 14-ны өдрөөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Нийслэл аудит” ХХК-ийн Аудитор Б.Өлзийзаяа, ахлах шинжээч Д.Чулуунбаатар, Д.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 1/270 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах, эрдэм шинжилгээ, инноваци, сургалтын аргагүй, технологийг хөгжүүлэх, боловсролын үйлчилгээний чанарыг орчин үеийн их сургуулийн түвшинд хүргэх, багш боловсролын чанараар Ази тивд өрсөлдөхүйц их сургууль байх, сургалт, судалгаа хосолсон нээлттэй, орчин үеийн их сургууль байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь Боловсрол Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын төсвийн багцад нэгтгэгддэг. “Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд 9 салбар сургууль, 5 дотоод алба нэгж гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Архивын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Татварын тухай хууль болон бусад хууль тогтоомжууд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 46 дугаар тогтоолоор "Оюутан хөгжлийн зээл"-ийг Боловсролын зээлийн сангаар дамжуулан олгохоор шийдвэрлэсэн ба тус тогтоолд зээлийг 5 дугаар сарын 1-ээс эхлэн олгохоор тусгасан.

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/158 дугаар захирлын тушаалаар шинэчлэн батлаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сургуулийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн бана.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Боловсролын Их Сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous", "Plastic" програм хангамж ашигладаг байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсан эсэх нь эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны нийт зардал 30,281.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 605.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт тус байгууллагын хувьд харьцангуй бага эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 50 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 12 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- 395.9 сая төгрөгийн их засварын зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулах
- Данснаас хасагдсан үндсэн хөрөнгөд хамаарах дахин үнэлгээний 6.9 сая төгрөгөөр дахин үнэлгээ дансыг бууруулах
- Тавьж олгосон 1,916.0 сая төгрөгийн бараа материалыг хуримтлагдсан үр дүн болон, тайлант хугацааны үр дүнд бичилтийг хийж зардалд хүлээн зөвшөөрөх зэрэг болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| | | | | (Сая төгрөгөөр) |
|-----|---|-----|-------|-----------------|
| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
| 1 | Зөвлөмж өгсөн | 2 | 131.5 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | - | - | |
| 3 | Албан шаардлага өгсөн | - | - | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | - | - | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | - | - | |
| Дүн | | 2 | 131.5 | |

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа материалын дансны ажил гүйлгээ, үндсэн хөрөнгийн засварын зардлын бүртгэл, авлага өглөгийн тооцоо нийлэлт, барагдуулалт зэрэг асуудлыг 2019 оны завсрын аудитаар үзэх болно

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой үндсэн болон туслах үйл ажиллагаанд зориулан Сургуулийн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 11 тоот тогтоолоор 2018 онд 35,450.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл нь 31,209.8 сая төгрөг буюу 88 хувьтай байгаа нь цалин, тэтгэмж, хангамжийн материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал дутуу зарцуулагдсанаас шалтгаалжээ.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 32,036.8 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь 2018 онд элсэгчдийн тоо өмнөх оныхоос буурсанаас шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод, мэдээллийг бүрэн оруулсан байна. Байгууллагын цахим хуудас <http://www.mnue.mn/> сайтад шилэн дансны цэсийг холбосон. Мөн бүрэлдэхүүн сургууль бүрээр болон нэгтгэсэн жилийн эцсийн санхүүгийн тайланг оруулсан байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

2. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтий илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын тооцоо нийлэлтийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн харилцагч байгууллагуудтай хийсэн тооцоо нийлсэн актын нийт дүнг санхүүгийн тайлан, ерөнхий журналын дүнтэй тулгаж шалгахад 109.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Насжилт өндөр найдваргүй авлага үүсэх, холбогдох хууль тогтоомж үйл ажиллагаанд хэрэгжихгүй байх эрсдэлтэй

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах талаар холбогдох дээд байгууллагатай хамтран ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Мөнгөн хөрөнгийн кассаар гарсан өндөр дүнтэй ажил гүйлгээний талаар

3.2.1 Илрүүлэлт:

2018 оны нийт кассын ажил гүйлгээг ерөнхий журналаас анхан шатны баримт руу хөөн шалгахад кассын ажиллагааны журамд заасан дээд хязгаараас хэтрүүлэн өндөр дүнгээр гүйлгээ хийсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2. Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ (ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна. Үүнд: ЖБТ 1,000,000,000 төгрөгөөс дээш бол ЖМС 1,500,000- 3,000,000 төгрөг 6.3-д Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000 (таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Мөнгөн хөрөнгө хяналтгүй зүй бусаар зарцуулагдаж, алдаа залилан гарах, холбогдох хууль тогтоомж үйл ажиллагаанд хэрэгжихгүй байх эрсдэлтэй

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид заавар журмыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Цаашид дээр дурдсан зөрчлүүдийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|------------------------------------|--------------------------|---------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 37,052,182,219.56 | 37,024,604,511.34 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 26,183,722,480.07 | 25,986,666,644.63 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 21,796,704,809.08 | 14,405,168,755.44 |
| 31210 | Төгрөг | 21,796,704,809.08 | 14,405,168,755.44 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 21,796,704,809.08 | 14,405,168,755.44 |
| 31500 | Хадгаламж | 4,387,017,670.99 | 11,581,497,889.19 |
| 33 | АВЛАГА | 7,969,445,613.73 | 9,422,720,541.37 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,322,093.71 | 1,868,539.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 5,914,005,832.76 | 6,263,630,623.86 |
| 33500 | Бусад авлага | 2,050,117,687.26 | 3,157,221,378.51 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 2,033,793,317.26 | 3,139,201,502.51 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 16,324,370.00 | 18,019,876.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 1,071,310,620.00 | 1,512,097,821.84 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 158,978,600.00 | 599,476,806.44 |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 912,332,020.00 | 912,621,015.40 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 61,372,620.00 | 17,739,820.00 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 848,320,000.00 | 853,195,500.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 250,000.00 | 7,570,351.00 |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 2,389,400.00 | 34,115,344.40 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,827,703,505.76 | 103,119,503.50 |
| 35100 | Түүхий эд материал | 2,193,295.50 | 38,500.00 |
| 35130 | Эм боох материал | 2,193,295.50 | 38,500.00 |
| 35400 | Хангамжийн материал | 1,816,620,010.26 | 103,081,003.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 148,556,602.72 | 50,627,046.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,457,395,224.43 | 51,867,807.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,990,841.00 | 243,800.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 663,295.51 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 50,690,544.57 | 46,200.00 |
| 35460 | Хүнсний материал | 879,625.00 | 146,250.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 152,443,877.03 | 149,900.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 55,455,421,561.07 | 66,786,046,277.55 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 55,455,421,561.07 | 66,786,046,277.55 |
| 39100 | Газар | - | - |
| 39200 | Биет хөрөнгө | 55,178,610,463.20 | 65,010,138,756.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 87,678,126,169.00 | 52,999,139,962.84 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -39,987,637,652.59 | -236,525,124.90 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 412,804,898.00 | 398,304,898.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -236,410,407.90 | -261,129,898.42 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 6,647,256,838.90 | 7,564,475,028.71 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -3,383,493,123.67 | -4,409,023,263.09 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5,951,736,710.74 | 6,470,709,102.79 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3,004,822,267.02 | -3,589,244,193.72 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 712,723,963.96 | 1,175,127,233.07 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -551,433,732.35 | -5,940,302.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,620,000.00 | 113,917,834.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -546,666.59 | -27,890,877.65 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 0.00 | 3,801,655,597.00 |
| 39217 | Ном | 937,685,732.72 | 1,016,562,759.72 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 276,811,097.87 | 1,775,907,521.38 |
| 39301 | Програм хангамж | 718,913,449.90 | 753,460,949.90 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -442,102,352.03 | -610,355,788.52 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 1,632,802,360.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 92,507,603,780.63 | 103,810,650,788.89 |

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|--------------|---|--------------------------|---------------------------|
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 9,839,235,192.86 | 8,800,131,070.13 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 9,839,235,192.86 | 8,800,131,070.13 |
| 41300 | Өглөг | 1,559,562,470.77 | 546,148,441.26 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 76,872.44 | 4,087,724.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 23,390,646.60 | 77,650.88 |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 9,788,342.02 | - |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 154,914,243.39 | 57,487,400.00 |
| 41360 | Бусад өглөг | 1,371,392,366.32 | 484,495,666.38 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 66,970,471.04 | 436,205,186.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,301,613,000.00 | 1,929,467.83 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 16,746.55 | 3,903,359.48 |
| 41364 | НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 2,792,148.73 | 42,457,653.07 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 8,279,672,722.09 | 8,253,982,628.87 |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 1,216,702,982.29 | 427,536,817.21 |
| 41420 | Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | 7,062,969,739.80 | 7,826,445,811.66 |
